



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.10.01 № 03/1906
танай _____-ны № _____-т

**Тендерийн баримт бичигт нэмэлт
өөрчлөлт оруулах тухай**

Тус газраас 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр зарласан Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх НХААГ/20240101549 дугаартай "СХД, 129 дүгээр сургуулийн авто замын үргэлжлэл" ажлын магадлал хийгдсэн зураг, төсвийг захиалагчийн хяналт тавих байгууллагаас ирүүлсэн тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу тендерийн шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

№	Тендер шалгаруулалтын баримт бичгийн заалт	Орсон өөрчлөлт
1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1 дэх заалт: Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр, Цаг: 12 цаг 00 минут	Тендерийн хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр, Цаг: 09 цаг 00 минут гэж;
2	Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.2 дахь заалт: Тендер нээлт хийх хугацаа нь: 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр, Цаг: 12 цаг 30 минут гэснийг;	Тендер нээлт хийх хугацаа нь: 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр, Цаг: 09 цаг 30 минут гэж;

Мөн захиалагч байгууллагаас 2024 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн 03/2274 дугаартай албан бичгээр дээрх төсөл арга хэмжээний магадлалаар баталгаажсан ажлын зураг төсөв, холбогдох материалыг ирүүлсэнтэй холбогдуулан сонирхогч этгээд тендер шалгаруулалтын үнийн саналыг тооцож ирүүлэхдээ Зам тээврийн хөгжлийн төвийн 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 408/2024 тоот магадлалын дүгнэлтээр баталгаажсан ажлын төсвийн дүн болох 475,586,213 төгрөгт багтаан ирүүлнэ үү.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд

нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно. Ажлын зураг төсвийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн “ТЭЗҮ” хэсгээс харна уу.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
Удирдлага
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Даваадорж Батцэцэг
2024.10.01 16:13